

**Нислэгийн цаг уурын төвийн  
2019 оны 08 дугаар сард хийсэн ажлын тайлан**

2019.08.28

**Зорилт:**

Нислэгт цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх, нислэгийн зөрчил саатлын тоог бууруулах, албан хаагчдын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилт тавин ажилласан. Төвийн 2019 оны 8 дугаар сарын ажлын гүйцэтгэл 98.7 хувьтай байна.

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 08 дугаар сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ 210, урт хугацааны урьдчилсан мэдээ 128, районы урьдчилсан мэдээ 217, угталтын урьдчилсан мэдээ 162, өндрийн салхины урьдчилсан мэдээ 248, аэродромын урьдчилсан мэдээ 62, SIGMET 103, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 215, Тосонцэнгэл нисэх буудал орчмын TAF 64, Ханбумбат нисэх буудал орчмын TAF 156, Овоот нисэх буудал орчмын TAF 23, бусад нисэх буудал орчмын урьдчилсан мэдээ 60 удаа тус тус гаргаж, олон улсын 1391, орон нутгийн 915, онцгой ба тусгай үүргийн 16 нислэгийг 552 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын төрөл бүрийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Хэрэглэгчдийн хүсэлтээр цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахимаар өгч байна. Төв орон нутгийн 2472 бодит мэдээ, 7253 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 8 дугаар сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээлэх систем /WAFS/-ийн бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 0.41%-иар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 1.84%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын байдлаас шалтгаалсан нислэгийн саатлын судалгаа: 8 дугаар сард нийт 37 саатал гарсан байна. Үүнд: таарсан 34, таараагүй урьдчилсан мэдээ 3.

*Нислэгийн саатлыг үзэгдэл элементээр нь үзүүлвэл:* Баруун хойдын салхитайгаас 27 нислэгийн гарсан бөгөөд урьдчилсан мэдээ таарсан 27, Зүүн өмнөдийн салхитайгаас 4 нислэг саатсанаас таарсан 2 таараагүй 2, нам үүлтэйгээс 3 нислэг саатсанаас таарсан 3, Борооны бөөн үүлтэйгээс 4 нислэг саатсанаас таарсан 3 таараагүй 1.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын бодит ажиглалтын мэдээ-1460, Уур амьсгалын ажиглалт-240, харьцуулсан ажиглалт-22, аюул-2, агаар-0, сарын дундаж мэдээ-4 удаа зохиосон.

Орон нутагт:

Олон улс болон орон нутгийн агаарын шугамд нислэг үйлдсэн үндсэн буудлын 921, бэлтгэл буудлын 1285 нислэгт, нислэгийн чиглэлийн урьдчилсан /НИ-5/ мэдээ 560, угталтын урьдчилсан мэдээ 166, буудал орчмын бодит мэдээ 6583, буудал орчмын урьдчилсан мэдээ 2287, районы урьдчилсан мэдээ 715, аэродромын урьдчилсан мэдээ 416, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 1044, нам өндрийн нислэгийн замын дагуух аюултай үзэгдлийн мэдээ 5, зурвасын гадаргын байдлын мэдээг 37 дамжуулж үйлчилсэн.

Орон нутагт цаг агаараас шалтгаалсан 5 нислэгийн саатал гарсан бөгөөд районы цаг агаараас шалтгаалж 3, замын цаг агаараас 1, Дэглий цагаан нисэх буудалд салхитайгаас буцсан 1 нислэг саатсан байна.

Бусад ажлын талаар:

- НХҮА-тай байгуулсан гэрээнийн хүчинтэй хугацаа 2019 оны 08 сарын 10-нд дуусч байгаа тул гэрээнд оруулах саналыг НААХЗА-ны үзлэг шалгалтаар өгсөн DOC9377-д нийцүүлэх зөвлөмжийн дагуу боловсруулан НХҮА-нд хүргүүлсэн. Гэрээг дүгнэх, гэрээнд өөрчлөлт оруулах хамтарсан уулзалтыг 8 сарын 1-нд хийж гэрээг сунгасан.
- 08 сарын 01-нд “УБХОУШНБ-ын үйл ажиллагааг эхлүүлэх төлөвлөгөө”-нд төвийн даргыг орлон гарын үсэг зурсан. УБХОУШНБ-ын ашиглалтын өмнөх захиргааны албанаас ЗТХЯ-ны сайдаар батлуулахаар оруулсан.
- 8 сарын 15-ны хоногийн нислэгийн төлөвлөгөөнд нөөц буудлууд тусгагдаагүй ирсэн. ИНД91-ийн дагуу FPL –с авах талаар цахим шуудан ирүүлсэн байсан тул 15-нд НУТА, болон АНБЗГ-ын менежер Гантөгс нартай уулзалт хийж 14 хоногийн хугацаанд нисэх буудлууд болон агаарын тээвэрлэгчидтэй холбогдож бэлтгэл буудлуудын мэдээллийг авч орон нутаг түгээх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар чиглэл авсан. 19-нд НБУГ-ын дарга болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулсан. 8 сарын 20-нд бүх гэрээт авиакомпаниудад бэлтгэл буудлын талаар албан тоот боловсруулан хүргүүлсэн.
- ИНЕГ болон ЦУОШГ-тай хамтран ажиллах ерөнхий гэрээний хугацаа дуусч байгаатай холбогдуулан орон нутгийн УЦУОШТ-дээд ирсэн саналыг хүлээн авч ЦУОШГ-ын дэд дарга Баттулга, төвийн дарга болон бусад холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн. 8 сарын 22-нд АНБЗГ, болон НБУГ-аас гэрээнд санал авах талаар албан тоот хүргүүлсэн.
- 8 сарын 20-22-ны өдрүүдэд Булган аймгийн УЦУОШТ болон нисэх буудалд төлөвлөгөөт шалган зааварлалт хийсэн.

Сургалт дадлага, хурал, семинар:

Орон нутгийн УЦУОШТ-үүд болон нисэх буудлуудаас			
Нэрс	Албан тушаал	Аймаг	Хугацаа
Э.Оюунтунгалаг	Техникч	Ховд аймгийн УЦУОШТ	2019.07.29-08,09
Н.Лхагвасүрэн	Техникч	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	2019.08.01-08.12
Б.Үүрийнтуяа	Синоптик инженер	Булган аймгийн УЦУОШТ	2019.08.22-оос
Ч.Мэндсайхан	Синоптик инженер	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	2019.08.23-аас

***Дүгнэлт:***

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 8 дугаар сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.